



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 2/10

Дэлгэрхаан сум

Тооллогын ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ны 238 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2026 оны 143 дугаар "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга: Ц.Золзаяа
(Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:
У.Ариунтуяа
(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)
Б.Бүжинлхам
(2 дугаар багийн Засаг дарга)
Б.Мөнхболд
(3 дугаар багийн Засаг дарга)
Г.Батнасан
(5 дугаар багийн Засаг дарга)
Д.Түмэнцэцэг
(Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Нарийн бичгийн дарга: С.Цэцэгсайхан
(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг байгууллагын хэмжээнд хууль тогтоомж, гарын авлагын дагуу 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2026 оны 07 дугаар сарын 06-ны хооронд чанартай зохион байгуулж, хэрэгжилтийг ханган, дүнг нэгтгэж салбар комисст танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Ц.Золзаяа), гишүүдэд даалгасугай.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд зааснаар бэлтгэл ажлыг хангаж, тооллогод эд хөрөнгийг бүрэн хамруулж хамтран ажиллахыг нягтлан бодогч (О.Анхцэцэг), нярав (Л.Баатархүү) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

ДУРАНГОО

СГЦСМДБ 1077015007 8073374

2326070031

